



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/27

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.4, 9.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 11 сарын 21-ний өдрийн 58 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам, Байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгох журмыг тус тус боловсруулж, Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг тогтоох ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц Чогсомжав	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Б.Дархантөр	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Л.Бат-Октябрь	-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/
	С.Нямдаваа	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Мөнхжаргал	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	А.Гантөмөр	-Татварын хэлтсийн дарга
	Ч.Хос-Эрдэнэ	-Хэнтий аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний тэргүүн

2. Дээрх журмыг хуульд нийцүүлэн боловсруулж, 2018 оны 02 сарын 20-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

